



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/183

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд "Ковид-19"-ийн цар тахлын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн халдвараас урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаанд хэрэгцээтэй бамбар, хавьтлыг бүртгэх, шинжилгээ тандалтын процессийг автоматжуулах ПОС төхөөрөмжийг худалдан авах зардалд нийт 4600000 төгрөг /дөрвөн сая зургаан зуун мянган/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 4600.0 мянган төгрөг /Дөрвөн сая зургаан зуун мянган/ - ийг аймгийн Засаг даргын 2021 онд батлагдсан нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ